

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг улируулан сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг улируулан сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ
 - 1.1.4. Япон-Улсын иргэн Кацухико Мадоно
 - 1.1.5. Монгол Улсын иргэн Цэвэгжав овогтой Одмаа
 - 1.1.6. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Сандагжав овогтой Нэргүй
2. Компанийн дүрмийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улиран сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлын
25/03 тоот шийдвэрийн Нэгдүгээр ХАВСРАЛТ



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨСӨВ**

No	Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин урамшууллын төсөв	10	13,780,000	12	186,030,000
1.1	Дарга	1	1,950,000	12	23,400,000
1.2	Хорооны дарга	3	1,560,000	12	56,160,000
1.3	Гишүүн	5	1,300,000	12	78,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	650,000	12	7,800,000
1.5	НДШ-ийн зардал				20,670,000
2	Хурал болон бусад зардал				10,000,000
	НИЙТ ТӨСӨВ				196,030,000

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

№ 25/04

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.5.1 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1 Компанийн дүрмийн 2.2 дахь хэсгийг
*“Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн гудамж 13А хаягт байрлах “Алтан Жолоо Тауэр” оффис 10 давхар 01 тоот*
гэж өөрчлөх буюу хаягийн өөрчлөлт оруулах;
 - 1.2 Компанийн дүрмийн 4.2.10 дахь хэсэгт *“Төлбөрийн баталгаа гаргах”* гэж нэмэх буюу үйл ажиллагааны чиглэлийг нэмэх;
2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг энэхүү шийдвэрийн Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасны дагуу үйл ажиллагааны чиглэл нэмэх, Компанийн албан ёсны хаяг өөрчлөхтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг баталгаажуулах, бүрдүүлж өгөх, эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү шийдвэрийн Хавсралтаар батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн (Х.Хулан [redacted], М.Маралмаа [redacted] [redacted] -д үүрэг болгосугай.
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны чиглэл нэмэгдэж буйтай холбогдуулан шаардлагатай шийдвэр, журам баталж, мөрдүүлэн ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

